



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/203

Мөрөн сум

Төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, 32 дугаар зүйлийн 32.1.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. АНУ-ын Хөгжлийн агентлагийн хүмүүнлэгийн тусламжийн товчооны (USAID-BHA) санхүүжилтээр “Дэлхийн Зөн Монгол” Олон улсын байгууллагын хэрэгжүүлж байгаа зудын хохирлыг бууруулах хүрээнд цөөн малтай малчин өрхийг хамруулан буцалтгүй тусламж, өвс тэжээл болон бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлэх зорилго бүхий MONDER төслийг Арбулаг, Алаг-эрдэнэ, Түнэл, Тосонцэнгэл, Мөрөн, Их-Уул, Төмөрбулаг, Бүрэнтогтох сумдад хэрэгжүүлэхийг дэмжсүгэй.

2. Төсөлд хамрагдах дээрх сумдад Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулж төслийн шаардлагад нийцсэн малчин өрхүүдийг сонгож, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын засаг дарга нарт, төсөл, хэрэгжихтэй холбоотой шаардлагатай мэдээ мэдээлэл гаргах, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН